



THE WORLD OF THE LOTUS SUTRA

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Баясалцахын зүйл хэмээх 13-р бүлэг

Лусын охин бурхан болж хувирахыг харсан хүмүүс маш ихэд гайхан биширч, Шагжамүни буддагийн өмнө тус бүрнээ тангараг өргөцгөөв. Оточийн хаан бодисадва болон Их самбаат бодисадва нар “Бид бурхан багш таныг өөд болсны дараа ч энэхүү сургаалыг ертөнцөд түгээхийн төлөө хамаг хүчээ зориулах болно. Түүний төлөө өөрийн амь биеэ ч хайрлахгүй зүтгэмүй” хэмээн тангараг өргөв.


Түүнчлэн 500 архат болон 8000 суралцагсад ба суралцаж дуусагсад нар “Бид ертөнцөд сургаал түгээхээ андгайлмой” хэмээв. Ингэтэл Шагжамүни буддагийн хойд эх Гоодами шимнанц болон суралцагсад ба суралцаж дуусагсад шимнанц нар нэгэн зэрэг сууринаасаа босож, чин сэтгэлээсээ мөргөн, Шагжамүни буддаг нүд салгалгүй ширтэн зогсов. Шагжамүни будда тэдний бодлыг ойлгож, бурханы гэгээрэл олох баталгаа өгөв.

Рахулигийн эх Алдрыг баригч шимнанц энэхүү үйл явдыг хараад “би л бурхан болох баталгаа авалгүй үлдлээ” хэмээн сэтгэв. Шагжамүни будда түүний сэтгэлийг ойлгож, бурхан болох баталгаа өгөв. Алдрыг баригч шимнанц болон бусад эмэгтэй сүсэгтэн олон баярлан цэнгэлдэж, Шагжамүни буддад талархал илэрхийлэхийн зэрэгцээ бусад ертөнцөд энэхүү сургаалыг түгээхийн төлөө хичээхээ тангаргалав.

Шагжамүни будда түмэн олон бодисадва нарыг ширтэн суув. Шагжамүни будда нэг ч үг дуугарахгүй суух тул бодисадва нар ийнхүү өгүүлэв.

“Бид бурхан багш таныг өөд болсны дараа

хаана ч явсан энэхүү сургаалыг түгээх болно. Тиймээс Шагжамүни будда та нирваанд орсны дараа ч гэсэн биднийг ивээлдээ багтааж, хүч чадал хайрлагтун. Бид мунхаг хүмүүст муу хэлүүлж, шийдэм таягаар цохиулсан ч хүлцэн тэвчих болно. Ирээдүй цагт лам хүн хүртэл муу сэтгэл, зусар бялдууч зантай болж, гэгээрээгүй атал гэгээрсэн мэт бодох явдал байх биз ээ. Мөн чимээ аниргүй газар амьдарч, нийгмээс тусгаарлагдан, өөрийгөө жинхэнэ үнэний замаар явж байна хэмээн энгийн ард иргэдийг дорд үзэх хүн ч гарах биз ээ. Хэдий тийм боловч ямар ч хэцүү зүйлтэй тулгарсан бид бурхан багшийн сургаалыг санаж хүлцэн тэвчмүй. Бид Шагжамүни будда таны элч учир айж эмээх зүйл үгүй. Бид энэхүү судар номлохын тулд хамаг хүчээ зориулмой. Багш та сэтгэл амар байгтун. Бид таны өмнө, арван зүгийн бурхадын өмнө тангараглая. Та бидний сэтгэлийг нэвтлэн харж, ирээдүй цагт энэхүү сургаалыг айлдахыг зөвшөөрөгтүн” гэв.



Үрээ санасан дуу

Өнгөрсөн жилээс хойш уялдаа холбоог илэрхийлдэг “холбоо” гэдэг үгийг их сонсох боллоо. Түүнчлэн ганцаараа амьдардаг өндөр настай хөгшчүүл нас барсан гэх зүрх шимшрүүлсэн мэдээ сонсоод гэр бүл гэж юу вэ? Уялдаа холбоо гэж юу вэ? гэсэн бодол өөрийн эрхгүй бодогдоно.

Юуны өмнө гэр бүл гэж юу вэ гэдгийг авч үзье. Японы уламжлалт ёсоор бол гэр бүл гэсэн үзэл нь “ачлах” гэсэн ханз үгтэй нягт холбоотой байдаг. Үнэхээр л ханзны утгын дагуу хүүхэд нь эцэг эхээ хүндэлж, халамжилж, эцэг эх нь хүүхдээ хайрлан энхрийлэх гэсэн энэрэл хайраар гэр бүл холбогддог. Рисшо Косей Кайд “эцэг эхээ ачлах”, ба “өвөг дээдэстээ зориулж ном унших” явдлыг чухалчилдаг нь энэхүү японы уламжлалт гэр бүлийн ёстой холбоотой юм.

Японд “ачлах ёс”-ыг чухалчилдаг Күнзийн суртлын нөлөө болон “нигүүлсэхүйн сэтгэл”-ийг чухалчилах буддизмын ухагдахуун холилдож, хүндэтгэл хайраар холбогдох гэр бүлийн дүр төрх бий болсон гэж ойлгож болно.

Эцэг эх, үрийн сэтгэлийн уялдааг японы эртний “Ман-ёо” хэмээх дууны төрлийн дуучин Яманоүэ Окүра-гийн дуунаас харж болно. “Хол газар сэлгүүцэн явж байхдаа үрийнхээ дуртай жимстэй тааралдлаа. Идсэн чинь үрээ санаад болдоггүй. Нүдээ аньсан ч үр минь харагдаад нойр хүрдэггүй”. Эртний Ман-ёо дуун дахь ийм өнгө аяс японы гэр бүлийн уялдаа холбоог бий болгох үндэс болдог гэж хэлж болно.



Хайр хүндэтгэл хэмээх утсыг ээрэх нь

Дээрх “ачлах” гэсэн ханз үсэг нь эцэг эх ба үрийн холбооноос гадна ахмад ба залуу хүмүүс хоорондын холбоог ч илэрхийлдэг. Ази хүмүүсийн хувьд “Бидний аз жаргал бол өвөг дээдсийн маань ач буян, үр ач нарын маань аз жаргал бол бидний хийх үйлээс хамаарна” гэж сургадаг.

Өнөө үед ч гурван үе, бүр дөрвөн үеэрээ ч хамтдаа амьдардаг гэр бүл мэр сэр байдаг. Олуулаа амьдардаг хүмүүс янз бүрийн л асуудалтай байдаг. Гэвч гэр бүлийн асуудал, зовлон нь хүнийг хамгийн их хатуужуулдаг билээ.

Ингээд бодохоор хааяадаа үглээ мэт санагдах өвөө эмээ, эцэг эх эсвэл үр, ачтайгаа өнгөрүүлэх өдөр бүрийн амьдрал нь үнэндээ биднийг өөр үзэл бодол, ондоо үеийнхнийг ойлгож чаддаг болох дасгал болдог бөгөөд тэр ядаргаатай мэт санагдах гэр бүлийн харилцаа нь хүний сэтгэлийг хатуужуулах хамгийн сайн хэрэгсэл болдог. Мөн Ишикава Такүбокүгийн “найз нөхөд ихэмсэг харагдах үед цэцэг худалдан аваад эхнэр дээрээ очно” хэмээх дуу шиг гадны хүнд хэлж чадахгүй зовлонг сонсож, хүлээн авдаг нь гэр бүл биш гэж үү.

Өөрөөр хэлбэл бие биенээ боловсруулан хөгжүүлж, харж хандаж ээрдэг хайр хүндэтгэл хэмээх утсаар гэр бүл холбогддог гэсэн үг юм. Гэр бүл энэрэхүй, талархалын сэтгэлээр бялхаж, гэрийн эзэн нь судар номоо дээдэлж, эхнэр нь зөөлөн дулаан уур амьсгалыг бүрдүүлэх гэр бүлийн утас хэзээ ч тасарахгүй.

Гэвч ийм уялдаа холбоо гэдэг нь зөвхөн гэр бүлийн дотор л байдаг зүйл биш. Тус нийгэмлэгийн салбар сүмүүд гишүүд болон гишүүн биш хөрш зэргэлдээх олон хүмүүстэй ийнхүү энэрэнгүй сэтгэлийн уялдаа холбоо тогтоохыг хичээж байна. Ганцаар амьдардаг хүмүүсийн гэрээр очиж уулзаж ярилцах “Найз нөхдийн хайр” үйл ажиллагаа нь ганцаараа амьдардаг хүмүүс ганцаардмал болохоос сэргийлж, бие сэтгэлийг нь аврах бодисадвагийн үйл билээ. Уг үйл ажиллагаагаар дамжуулан хүмүүс хооронд амгалан тайван уялдаа холбоо бий болох юм.

Хүнийг чин сэтгэлээсээ энэрэн хайрлах нь нигүүлсэхүйн үйлийг хэрэгжүүлж байна гэсэн үг билээ.

“Косэй” 2012 оны 7 сарын дугаараас



ИНЭЭМСЭГЛЭЛ БОЛ ТЭНГЭРИЙН ЦЭЦЭГ

Рисшо Косей Кай Нийгэмлэгийн Ирээдүйн Ерөнхийлөгч
Нивано Коошо

Өвөөгийн дүр төрх

Намайг хүүхэд байх үед зурагтаар Иран улсад сууж байсан америкийн ЭСЯ-ны ажилтан барицаалагдлаа гэсэн мэдээ гарч байлаа. Өдөр бүр гарах мэдээнээс хэцүүхэн юм болжээ гэдгийг би ойлгов. Хаа нэгтээ хол газрын адал явдал гэж бодож байсан миний чихэнд нэгэн орой итгэхийн аргагүй зүйл сонсогдов. Өвөө маань тэр барьцаалагдсан хүнээр өөрийгөө солихоор Иран уруу явна гэв. Япон, Америкийн улс төрийн байгууллага Ираны ЭСЯ-тай холбоо барьж байгаа гэж ярихыг бодоход үнэн юм шиг байлаа.

Хаа байсан хол газрын үйл явдал манай гэр бүлд нөлөөлж, гэр бүлийн хайртай хүнийг хүртэл аваад явах нь. Гэвч би хүүхэд байсан тул “Битгтй яваач” гэж хэлж чадахгүй, гагцхүү айдас, зовинолоор дүүрч байв.

Тэр үеэ дурсан санахад нүдний өмнө өвөө маань өдөр бүр гэртээ байхдаа сольж өмсдөг байсан хувцастайгаа сууж байх нь харагддаг. Тийм том шийдвэр гаргачихаад ямар ч тоосон шинжгүй гэртээ байдгаараа байж байх нь надад бурхан мэт сүртэй харагдаж байв. Би ер нь өвөөдөө их хайртай, байнга өвөөгийн яриаг сонсох дуртай байв. Түүний хүүхэд ахуйн дурсамж, хотод орж ирсэн тухай яриа, цэрэгт явж байсан тухай, Косэй-кай байгуулагдаж байсан үеийн тухай, найз нөхөд, гадаад орны яриа, дэлхийн энх тайвны тухай гээд яриаг нь сонсох дуртай байлаа. Өвөөгийн ярьдаг байсан ярианууд үргэлж гэрэл гэгээтэй, итгэл найдвар, зориг, мөрөөдлөөр дүүрэн байдаг байсан.

Өвөө маань үргэлж хүний аз жаргалын төлөө боддог байсан ба хүмүүс өвөөг их шүтдэг байв.

Тэрээр РКК-г байгуулж, олон хүнийг аз жаргалд хөтөлж, дэлхийн энх тайвны төлөө хүртэл хамаг хүчээ зориулдаг



Нивано Коошо

Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагтай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн дараагийн ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

байсан. Мөн өвөө маань тухайн үе бүрийн ерөнхий сайд нартай уулзахаас гадна олон ч улсын сайд түшмэлтэй уулзаж гишүүд төдийгүй дэлхий нийгмийн төлөө зүтгэдэг байсан юм. Би тийм мундаг өвөөгөөрөө их бахархдаг байлаа. Гэтэл өвөө маань бүх юмаа хаяад өөрийнхөө амь насыг ч хайрлалгүй хаа байсан хол газрын гэмт хэрэгтнүүдийн гарт орох гэж байдаг. Миний сэтгэлийн гүнд “жинхэнэ” гэсэн үг гарч ирэв. Өвөө маань бидний хувьд зүгээр нэг “Үүсгэн Байгуулагч” биш “жинхэнэ хүн шиг хүн” гэдгийг би мэдэрсэн юм.

Энэ хорвоод жинхэнэ бодисадватай учирч, түүнийг “багш аа” гэж дуудах нь ямар их аз жаргал вэ.

Өнөөгийн Японд хэн ч бодож сэтгээгүй, санаанд оршгүй зүйл олон тохиолдож байна. Чухам ийм үед л би өвөөгийнхөө тэр үеийн тайван сайхан дүр төрхийг дурсан санадаг юм. Юу ч тохиолдсон айж, эмээлгүй зөвхөн бодисадвагийн үйлээ л хийж байсан өвөөгийн дүр төрх. Үүсгэн Байгуулагчийн тэрхүү дүр төрхийг мартаагүй үед бид юу ч хийж чадна.

Яг одоо бид бүхэн жинхэнэ бодисадва болох цаг ирлээ. Хамтдаа хамаг амьтан бүхнийг авархын төлөө.

Ажил дээрээ найрсаг харилцааг бий болгох нь

Олон улсын буддист нийгэмлэг Бангладеш гишүүн
Дэбашис Баруа

Намайг Дэбашис Баруа гэдэг. Би Бангладешт буддын шашинт гэр бүлд төрж өссөн. Манай гэр бүл бурханы сургаалыг хатуу баримтлахаас гадна лам хуврагыг хүндэтгэдэг билээ. Би бага байхаасаа л Гоотама буддаг ихэд дээдэлдэг байсан. Өглөө, өдөр, орой өдөрт 3 удаа бурхандаа мөргөж залбирдаг байв. Намайг бага байхад ээж маань Гоотама буддагийн намтар түүх болон бурханы сургаалын тухай ярьж өгдөг байсан.

Би Дакка их сургуулийн магистрыг биохимийн мэргэжлээр төгссөн бөгөөд докторын зэрэг хамгаалахаар 2002 онд Японд ирж Саитама мужийн Вараби хотод байдаг дүүгийнхээ амьдрах болов. Дүүгийнх маань гэртээ бурхан тахилтай, ам бүл зургуулаа амьдардаг байв.

2 жил цагийн ажил хийнгээ япон хэлний сургууль төгсөж, нэгэн компанид судлаач оюутнаар 3 жил дадлага, судалгааны ажил хийсэн.

2006 онд аавын маань зүрх гэнэт зоссоны улмаас ухаан алдан унаж, баруун талын бие нь мэдээгүй болсон юм. Би гэр бүлийнхээ төлөө сургуулиа орхиж Канагава мужийн Чигасаки хотод байдаг гени судлалын компанид ажилд оров. Ажиглагчаар 2 жил ажилласан боловч ажил гэрээс хэт хол байсан тул 2008 оны 11 сард одоогийн



ажиллаж буй химийн компанидаа эргэн орсон. Судалгаа, шинжилгээ хийж, задлан шинжлэх ажлыг ахмад ажилтнуудаас суралцаж, түүнээс хойш биеэ даан төлөвлөгөө гарган ажиллаж ирсэн.

Тэр үед Буддын байгууллагад орж, ижил сүсэг бишрэлтэй хүмүүстэй хамт бурханы сургаалыг суралцах хүсэл төрсөн юм. Яагаад гэвэл ганцаараа бурханы үйл хийх боломжгүй гэж бодсон юм. Ингээд интернэтээр дамжуулан Шагжамүни буддаг тахин шүтдэг Рисшо Косей Кайгийн Олон улсын буддист нийгэмлэгийг олсон юм. 2009 онд Бүтэнсайны цуглаанд оролцож маш сайхан санагдсан. Олон удаа үйл ажиллагаанд оролцож үзсэний эцэст 10 сард гишүүнээр элсэж, бурхан залав. Дараа жил нь өвлийн номын уншлагад оролцож, “Arms Down” зэвсэгт мөргөлдөөний эсрэг энх тайвны хөдөлгөөний хүрээнд Олон улсын буддист нийгэмлэгийн тэргүүн Сүзүки болон бусад залуу гишүүдтэй хамт хөл хөдөлгөөн ихтэй Гинза, Харажүкү гудамжаар явж гарын үсэг цуглуулав. Икэбүкүрод болдог Бангладешийн баярт хүртэл очиж гарын үсэг цуглуулсан бөгөөд нийт 200 хүний гарын үсэг цуглуулсан юм.

Энэ жил 1 сард хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнөөр бүтээгдэхүүний хяналтын хэлтэст рүү шилжив. Уг хэлтэст насаар ах 7 гэрээт ажилтанг хариуцан ажиллах болов.

Өнөөг хүртэл үргэлж ганцаараа ажиллаж ирсэн учир ижил түвшний, түвшин доогуур гээд янз бүрийн хүмүүстэй баг болж ажиллах нь миний хувьд анхны тохиолдол байв.

Шинэ хэлтэст шилжсэнээс хойш үйлчлүүлэгч болон ажилтнуудаас өдөр бүр гомдол тасрахгүй байв. Барааг андуурч илгээх, эсвэл шалгаж дуусаагүй барааг үйлчлүүлэгч рүү илгээх зэрэг алдаа их гарч байв. Иймэрхүү алдааг арилгая гэж хичнээн хичээсэн ч гомдол тасрахгүй л байв. Гомдлын шалтгааныг хайгаад үзвэл хэд хэдэн асуудал байгааг олов. Түүний нэг нь алдаа гарсан үед тохирох арга хэмжээг авахгүй байсан явдал байв. Би ажилтнууддаа алдаа гарвал тэр даруй

SPIRITUAL JOURNEY

мэдэгдэхийг хүсэв. Тэгэх юм бол дараагийн арга хэмжээг авч чадна гэж бодов. Гэсэн ч ажилтнууд маань гаргасан алдаагаа нуугаад хэлэхгүй байв. Энэ асуудлыг шийдвэрлэх арга олохын тулд ажилтнуудтайгаа өдөр бүр хурал хийх болов. Бүгд хэцүү байдалд орсон аятай шал ширтгээд шийдвэрлэх аргыг олж чадсангүй. Өдөр бүр хэцүү санагдаж, хоол идэх ч хүсэлгүй болж, шөнө нойр хүрэхээ болив. Явал алдааг багасгаж чадах тухай л боддог болов. Эцэст нь бүр ажлаасаа гарах талаар боддог болов. Дүү маань шаналж буй намайг хараад ажлаа солихыг ятгах болов.

Ингээд энэ жилийн 2 сарын 18-нд нийгэмлэгийн Япон хэлний багш Сүзүки Ясүёо руу утсаар ярьж зөвөлгөө авав. Багш “Бид бүгд нэгэн амьтай бөгөөд долгионоор холбогдож байдаг. Тиймээс тэндээс холдсон ч гэсэн бодол сэтгэл болон үг тань долгионоор дамжин нөгөө хүнд чинь хүрэх болно. “Баярлалаа” гэдэг үгэнд гайхалтай хүч агуулагдаж байдаг. Гэртээ 2 зүйлийг л хэрэгжүүлээд үз” гэж хэлэв. Ингээд би багшийн хэлсний дагуу хэрэгжүүлэв.

Нэгдүгээрт хүн бүрийн нэрийг дуудаж “Үргэлж надтай хамтарч ажилладагт баярлалаа” хэмээн талархах явдал. Хоёрдугаарт “таньд аз жаргалыг хүсье” хэмээн тухайн хүнийхээ аз жаргалын төлөө залбирах явдал юм. Багш хэлэхдээ “Сэтгэлээсээ хэлж чадахгүй бол хэлбэр төдий байсан ч болно. Сулхан хоолойгоор хэлсэн ч болно. Үгээр хэлэхгүй байсан ч болно. 10 хоног хийгээд үз” гэж зөвлөв. Би багшийн зөвлөсний дагуу өдөр бүр бурхандаа ажилтнуудынхаа аз жаргалын төлөө залбирч, талархлаа илэрхийлэх болов.

Ажилтнууддаа хэлж дамжуулахгүй байсан ч болох тул хэрэгжүүлэхэд тийм ч хэцүү байгаагүй.

3 дахь хоног дээрээ нэгэн зүйлийг анзаарсан юм. Бурханы сургаалд зөвхөн итгэж бишрэх бус сургаалыг бодитоор хэрэгжүүлэх нь буддизмын жинхэнэ мөн чанар гэж боддог. Тиймээс ажилтнуудынхаа төлөө зөвхөн залбирах бус явал хамт олонтойгоо ойр дотно болох аргыг хайя гэж бодов.

Тэгтэл нэгэн сайхан санаа толгойд орж ирэв. Ажилтнууд маань бүгдээрээ кофе уух дуртай ба амралтын цагаар кофе уунгаа ярилцан суудаг юм. Тэд автомат машинаас кофе авч ууж байв. Тиймээс би дараагийн өдөр нь кофе худалдан авч, тэдэнд кофе найруулж өгөв. Үүгээр дамжуулж бидний харилцаанд өөрчлөлт гарав. Тэд надтай гэр бүл, сонирхол, загасчлах, тэннис тоглох, аялалын талаар

чөлөөтэй ай ад янз бүрлж уудж уудаг болоярилцах болов. Үүгээр ч зогсохгүй ажил дээр гарч буй алдаа дутагдлын талаар хүртэл ярих болов.

Би тэдэнд “Ямар нэг алдаа гарвал надад хэлээрэй. Би шийдвэрлэж өгөх болохоор тайван байж болно” гэж хэлээд, алдаа гарвал шулуухан надад мэдэгдэх уур амьсгалыг бүрдүүлэхийг хичээв. Тэгтэл тэд надад ямарч зүйл байсан ярьж хэлдэг болов.

Түүнчлэн явал алдаа гарахгүй болох, ажлын үр дүнг сайжруулах аргыг хамтдаа боддог болов.

Түүнээс хойш 3 сар өнгөрөөд байгаа ба том алдаа ганц ч гараагүй. Алдаа гарах л юм бол шууд арга хэмжээ авдаг учраас хэрэглэгчдэд төвөг учруулалгүйгээр ажиллаж байна. Алдаа гарангуут би хэрэглэгч рүү утсаар ярьж уучлал гуйх “илгээмжийн мөнгийг компани төлөх учир шудангаар бараагаа буцаагтун” гэх арга хэмжээг авч байна. Ингээд би өөрийнхөө жинхэнэ хийх ёстой ажлыг хийх боломжтой болов.

Сүзүки багш “одоо дахин асуудал гарахааргүй болсон ч гэсэн үргэлж ажилтнууддаа талархаж явбал ажил улам л бүтэмжтэй байх болно” гэж захив.

4 сарын 15 нд байгууллагын Сакүра үдэшлэгийн үеэр захирал “Өнгөрсөн жил 5 сая иений алдагдал гарсан бол энэ жил бараг алдаа гарсангүй” хэмээн мэдэгдсэн юм. Одоо би ажилдаа үнэхээр дуртай болсон.

Бурханы сургаалыг бодитоор хэрэгжүүлж сайн үр дүнд хүрсэндээ баяртай байна.

Эцэст нь Бурхан багш болон Олон улсын буддист нийгэмлэгийн хамт олонд талархалаа илэрхийлье. Баярлалаа.




“ARMS DOWN” гарын үсэг цуглуулах хөдөлгөөн



Shanzai сэтгүүлд гишүүд бодит амьдрал дээр бурхан багшийн сургаалыг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай нийтэлж байна. Та ч гэсэн өөрийн туршлага дэлхийн олон орны гишүүдтэй хуваалцахгүй биз? Холбоо барих хаяг: shanzai.rk-international@kosei-kai.or.jp

shanzai

Жинхэнэ баян хүн



Сүүлийн үед мөнгөтэй, мөнгөгүй зэрэг эд мөнгө, гадаад үзэмжээр хүний аз жаргалыг хэмжих хандлага хүчтэй болсон. Энэ нь эд зүйлсийг шүтсэн нийгмийн хандлагын сөрөг тал юм.энд “Ядуу хүн гэж их эд зүйлгүй хүнийг хэлэхгүй, харин их шуналтай хүнийг хэлнэ” гэсэн Шведийн зүйр цэцэн үг байдаг.

Мөн Хятадын гүн ухаантан Лаози “сэтгэл ханахыг мэддэг бол тэр баян хүн юм” хэмээх үг байдаг бөгөөд нээрээ л сүүлийн үед эд зүйлийг хэт хүсэмжлэн сэтгэл нь хором ч амар амгалан байж чаддаггүй, сэтгэлээрээ ядуу хүмүүс их болсон шиг санагддаг. Эд хөрөнгө байсан ч түүнийг жинхэнэ утгаар нь ашиглах, амьдруулах аргыг мэдэхгүйгээр мөн бусдын төлөө үйл хийхийг мэдэхгүй хүнийг баян хүн гэж хэлэхгүй.

Эсрэгээр хоёр идэхгүй хоосон хонохгүй амьдралтай ч бусдын сайн сайхны төлөө бодож чадах сэтгэлтэй хүнийг баян хүн гэж хэлж болно. Түүнчлэн энэ нь зөвхөн хүн дээр яригдах асуудал биш юм. Эдийн засгийн үзүүлэлтээрээ тэргүүлдэг том улс гүрний хувьд ч ялгаагүй. Зөвхөн өөрийн улсын ашиг хонжоог хөөж, дэлхий нийтийн талаар бодолцдоггүй улс гүрнийг өндөр хөгжилтэй улс гэж хэлэхэд бэрх юм.



Гэртээ бурханы сургаалыг хэрэгжүүлэх нь

Өнгөрсөн жилийн эцсээр томилолтын хугацаа дуусч, 4 жил гэр бүлээсээ тусдаа амьдарсны эцэст дахин цуг амьдрах болов. Гэр бүлийхэнтэйгээ цуг амьдрах үнэхээр сайхан. Хэзээ нэгэн цагт үүрнээсээ нисэх үр хүүхдүүд болон амьдралын хамгийн сайн хань болох эхнэртэйгээ цагийг хамтдаа өнгөрүүлэх нь үнэхээр талархууштай.

Косей Кай нийгэмлэгийн сургаалын хамгийн гайхалтай талыг би бурханы сургаалыг энгийн амьдралдаа хэрэгжүүлэх гэсэн ойлголт хэмээн боддог. Гэртээ бурханы сургаалыг хэрэгжүүлснээр гэр бүлийн уур амьсгал амгалан тайван болно. Мөн сургаалыг хэрэгжүүлснээр сэтгэлээ хөгжүүлэн засаж, билэг оюунаа нээх боломжтой.

Энэ утгаараа би гэртээ өглөөний мэндчилгээ болон талархалын үг хэлэхээ мартажгүй байхыг хичээж байгаа.

Мөн өглөө бүр гэр бүлийхэнтэйгээ хамт судар унших нь юу юунаас илүү талархмаар зүйл билээ. Сургаалыг хэрэгжүүлснээр амьдралд тань гайхамшиг тохиолдох болно. Бурханы сургаалыг гэртээ хэрэгжүүлэхээр хамтдаа оролдоод үзье.

Олон Улсын Хэлтсийн дарга
Мизүтани Шооко

SHAN ZAI

Buddha's Wisdom Changes Your Life

Санал хүсэлт

“Shanzai” сэтгүүл нь та бүхний санал хүсэлтийг хүлээн авч байна.


Материал нийтлүүлэх, Буддизмын тухай мэдмээр байгаа зүйл, Ямар нэгэн асуудал зэргийн талаарх зөвөлгөө болон сэтгүүлийн талаарх санал хүсэлтийг бид баяртайгаар хүлээн авах болно.

Холбоо барих хаяг энэ хуудасны төгсгөлд хэвлэгдсэн байгаа. Та бүхнийг олон сайхан санал, хүсэлт илгээнэ гэдэгт найдаж байна.

Рисшо Косей Кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон Хамтран үндэслэгч Наганума Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулах гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм.

Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашны бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар барин, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Volume 82 (July 2012)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс, Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, Japan 166-8537 TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp
Senior Editor : Rev. Shoko Mizutani Editor : Ms. Etsuko Nakamura Editorial Staff: Ms. Shiho Matsuoka, Ms. Yukino Kudo, Ms. Kaoru Saito, Ms. Mayumi Eto, Ms. Sayuri Suzuki, Ms. Eriko Kanao, Ms. Emi Makino, and Ms. Yurie Nogawa

Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна. Зарим дугаар нь бусад орны хэл дээр хэвлэгдэх ториолдол байдаг.

Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.

Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.